



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/159/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг
Утас: 99377360 Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12-15
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19,20
7. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	21,22
8. Төлбөрийн акт, 01/160, 02/161, 03/162, 04/163.....	23-26
9. Албан шаардлага, 01/124, 02/125, 03/126, 01/147.....	27-30

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 270

танай _____ ны № _____ Т

РАШААНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ЖАРГАЛЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Рашаант сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалд нэг хүүхдэд ноогдох хоногийн махны хэрэглээг норм хэтрүүлэн 6,544.0 мянган төгрөг илүү зарцуулсан.

Үдийн цай хөтөлбөр арга хэмжээний зардлыг 2,294.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн.

Багш ажилтнуудад албан томилолт, ур чадварын нэмэгдэл, эрүүл мэндийн үзлэг, оношилгооны төлбөрт 1,311.3 мянган төгрөг илүү тооцож олгосон.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын заалтыг үндэслэн 4 багшид 4,633.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь цалинтай давхардсан байна.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа, зөрчлийн нийт дүн 14,782.3 мянган төгрөг байгаа нь төлөвлөсөн материаллаг байдлын түвшнөөс давсан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн

006026710

төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 180,366.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Ур чадварын нэмэгдэлд тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэлгүйгээр 8,814.3 мянган төгрөг олгосон нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын хавсралт дахь 2, 3, 4-т заасныг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвөөс олгосон урсгал засварын батлагдсан төсвөөс 13,613.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэгдээгүй, төсвийн шууд захирагчид үр дүнгийн урамшуулал олгогдоогүй байна. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт 44 багшаас 18 багш I-IV түшинд үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>193,789,997.27</u>	<u>345,569,640.61</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,801,606.00	180,366,711.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	53,801,606.00	180,366,711.00
3121	Төгрөг	53,801,606.00	180,366,711.00
31211	Төрийн сангийн харилцах	53,801,606.00	180,366,711.00
33	АВЛАГА	80,400.00	-
335	Бусад авлага	80,400.00	-
3351	Байгууллагаас авах авлага	80,400.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	139,907,991.27	165,202,929.61
351	Түүхий эд материал	4,636,724.00	5,862,724.34
35110	Тусгай зориулалттай материал	4,056,874.00	5,282,874.34
35130	Эм боох материал	579,850.00	579,850.00
354	Хангамжийн материал	135,271,267.27	159,340,205.27
35420	Аж ахуйн материал	100,938,112.36	96,854,912.36
35460	Хүнсний материал	16,062,052.00	30,571,590.00
35470	Бусад хангамжийн материал	18,271,102.91	31,913,702.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,058,379,988.45</u>	<u>4,136,334,764.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,058,379,988.45	4,136,334,764.54
392	Биет хөрөнгө	3,994,382,988.45	4,072,675,264.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,062,874,583.55	4,082,910,129.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,795,548.31)	(397,180,366.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,999,999.92)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	228,712,605.00	404,108,975.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(69,044,084.05)	(116,851,134.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,959,332.42	146,963,992.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,215,723.02)	(68,280,055.27)
39217	Ном	19,891,822.78	21,003,724.78
393	Биет бус хөрөнгө	63,997,000.00	63,659,500.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(675,000.00)	(1,012,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	63,322,000.00	63,322,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,252,169,985.72</u>	<u>4,481,904,405.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,125,041.00</u>	-

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,125,041.00	-
413	Өглөг	6,125,041.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,841,041.00	-
4136	Бусад өглөг	1,284,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,284,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,246,044,944.72	4,481,904,405.15
51	Засгийн газрын хувь оролцоо	4,246,044,944.72	4,481,904,405.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	810,581,904.00	810,581,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,497,837,120.30	1,737,971,248.87
51210	Өмнөх үеийн үр дүн	1,497,837,120.30	1,502,111,788.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	235,859,460.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,937,625,920.42	1,933,351,252.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,252,169,985.72	4,481,904,405.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,716,093,600.00	2,516,806,152.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	330,749,052.34
120	Нийтлэг татварын бус орлого	-	330,749,052.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	323,467,852.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	323,467,852.34
120009	Бусад орлого	-	7,281,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,716,093,600.00	2,186,057,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,372,413,500.00	1,835,117,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,009,700.00	1,835,117,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,368,403,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	343,680,100.00	349,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	343,680,100.00	349,839,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,796,548,725.14	2,261,620,152.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,796,548,725.14	2,261,620,152.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,743,471,883.68	2,180,050,798.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	964,797,283.00	1,217,926,148.00
210101	Үндсэн цалин	704,982,896.00	864,295,631.00
210102	Нэмэгдэл	205,103,970.00	306,217,797.00
210104	Урамшуулал	54,710,417.00	47,412,720.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,684,550.04	152,501,019.00

210201	Тэтгэврийн даатгал	82,577,679.06	104,147,702.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,708,843.98	12,222,530.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,720,029.31	9,936,347.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,879,818.31	2,393,733.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,798,179.38	23,800,707.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,447,641.00	300,162,844.97
210301	Гэрэл, цахилгаан	16,213,141.00	19,252,111.97
210302	Түлш, халаалт	270,434,500.00	277,310,733.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	3,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	754,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	754,500.00	-
2105	Нормативт зардал	146,229,088.20	128,775,050.00
210502	Хоол, хүнс	146,229,088.20	128,775,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	23,668,700.00
210604	Урсгал засвар	-	23,668,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,061,600.00	13,556,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,653,600.00	4,289,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,408,000.00	9,267,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,497,221.44	343,460,436.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,197,900.00	160,347,346.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,670,200.00	8,579,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,629,121.44	174,533,990.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,076,841.46	81,569,354.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,076,750.50	80,534,040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,076,750.50	80,534,040.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90.96	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90.96	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,035,314.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,035,314.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(80,455,125.14)	255,185,999.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.08	19,326,539.11
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.08	19,326,539.11
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.08)	(19,326,539.11)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(80,455,125.22)	235,859,460.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,716,093,600.00	2,193,338,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,281,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,281,200.00
120009	Бусад орлого	-	7,281,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,716,093,600.00	2,186,057,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,372,413,500.00	1,835,117,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,009,700.00	1,835,117,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,368,403,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	343,680,100.00	349,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	343,680,100.00	349,839,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,621,572,994.00	1,997,196,395.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,621,572,994.00	1,997,196,395.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,550,520,856.04	1,916,605,038.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,919,709.00	1,217,926,148.00
210101	Үндсэн цалин	706,105,322.00	864,295,631.00
210102	Нэмэгдэл	205,103,970.00	306,217,797.00
210104	Урамшуулал	54,710,417.00	47,412,720.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,684,550.04	152,501,019.00
210201	Тэтгэврийн даатгал	82,577,679.06	104,147,702.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,708,843.98	12,222,530.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,720,029.31	9,936,347.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,879,818.31	2,393,733.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,798,179.38	23,800,707.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,606,600.00	305,003,885.97
210301	Гэрэл, цахилгаан	13,756,641.00	23,964,685.97
210302	Түлш, халаалт	269,249,959.00	277,439,200.00
210303	Цэвэр, бохир ус	3,600,000.00	3,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	754,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	754,500.00	-
2105	Нормативт зардал	114,643,497.00	144,262,586.00
210502	Хоол, хүнс	114,643,497.00	144,262,586.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	30,186,900.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	30,186,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,061,600.00	13,556,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,653,600.00	4,289,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,408,000.00	9,267,200.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,650,400.00	53,167,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,033,200.00	40,454,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,617,200.00	12,713,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,052,137.96	80,591,356.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,052,047.00	79,556,042.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,052,047.00	79,556,042.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	90.96	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	90.96	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,035,314.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,035,314.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	94,520,606.00	196,141,905.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	40,719,000.00	69,576,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,719,000.00	69,576,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,719,000.00	69,576,800.00
222001	Тоног төхөөрөмж	40,719,000.00	45,166,700.00
223001	Бусад хөрөнгө	-	24,410,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(40,719,000.00)	(69,576,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	53,801,606.00	126,565,105.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		53,801,606.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,801,606.00	180,366,711.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,581,904.00	1,937,625,920.42	1,497,837,120.30	4,246,044,944.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,581,904.00	1,937,625,920.42	1,497,837,120.30	4,246,044,944.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,581,904.00	1,937,625,920.42	1,497,837,120.30	4,246,044,944.72
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	810,581,904.00	1,937,625,920.42	1,497,837,120.30	4,246,044,944.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,274,668.14	4,274,668.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,581,904.00	1,937,625,920.42	1,502,111,788.44	4,250,319,612.86

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(4,274,668.14)	-	(4,274,668.14)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	235,859,460.43	235,859,460.43
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	810,581,904.00	1,933,351,252.28	1,737,971,248.87	4,481,904,405.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,247,058,400.00	2,065,737,880.97	181,320,519.03	91.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,247,058,400.00	1,996,161,080.97	250,897,319.03	88.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,149,138,400.00	1,916,605,038.97	232,533,361.03	89.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,356,753,400.00	1,217,926,148.00	138,827,252.00	89.77
210101	Үндсэн цалин	931,499,500.00	864,295,631.00	67,203,869.00	92.79
210102	Нэмэгдэл	365,493,300.00	306,217,797.00	59,275,503.00	83.78
210104	Урамшуулал	59,760,600.00	47,412,720.00	12,347,880.00	79.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,594,900.00	152,501,019.00	17,093,881.00	89.92
210201	Тэтгэврийн даатгал	115,324,600.00	104,147,702.00	11,176,898.00	90.31
210202	Тэтгэмжийн даатгал	13,567,600.00	12,222,530.00	1,345,070.00	90.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,854,100.00	9,936,347.00	917,753.00	91.54
210204	Ажилгүйдлийн даатгал	2,713,500.00	2,393,733.00	319,767.00	88.22
210205	Эрүүл мэндийн даатгал	27,135,100.00	23,800,707.00	3,334,393.00	87.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,039,600.00	305,003,885.97	2,035,714.03	99.34
210301	Гэрэл, цахилгаан	25,000,000.00	23,964,685.97	1,035,314.03	95.86
210302	Түлш, халаалт	278,439,600.00	277,439,200.00	1,000,400.00	99.64
210303	Цэвэр, бохир ус	3,600,000.00	3,600,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	148,082,300.00	144,262,586.00	3,819,714.00	97.42
210502	Хоол, хүнс	148,082,300.00	144,262,586.00	3,819,714.00	97.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,800,000.00	30,186,900.00	13,613,100.00	68.92
210604	Урсгал засвар	43,800,000.00	30,186,900.00	13,613,100.00	68.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,556,600.00	13,556,600.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,289,400.00	4,289,400.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,267,200.00	9,267,200.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,311,600.00	53,167,900.00	57,143,700.00	48.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,410,800.00	40,454,100.00	55,956,700.00	41.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,900,800.00	12,713,800.00	1,187,000.00	91.46

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,920,000.00	79,556,042.00	18,363,958.00	81.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,920,000.00	79,556,042.00	18,363,958.00	81.25
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,920,000.00	79,556,042.00	18,363,958.00	81.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	69,576,800.00	(69,576,800.00)	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	69,576,800.00	(69,576,800.00)	
222001	Тоног төхөөрөмж	-	45,166,700.00	(45,166,700.00)	
223001	Бусад хөрөнгө	-	24,410,100.00	(24,410,100.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,902,108,800.00	2,184,957,100.00	(282,848,300.00)	114.87
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,841,007,900.00	1,835,117,900.00	5,890,000.00	99.68
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,841,007,900.00	1,835,117,900.00	5,890,000.00	99.68
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	349,839,200.00	(349,839,200.00)	
132001	Орон нутгийн төсвөөс	-	349,839,200.00	(349,839,200.00)	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,100,900.00	-	61,100,900.00	0.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,059,300.00	-	4,059,300.00	0.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,240,000.00	-	3,240,000.00	0.00
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	53,801,600.00	-	53,801,600.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		53,801,606.00	(53,801,606.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		180,366,711.00	(180,366,711.00)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 11,815.9 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 37,209.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,843.4 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 7,938.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 22,427.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Дотуур байрны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах мах, махан бүтээгдэхүүний норм, хэмжээг нэмэгдүүлж, 6,544.0 мянган илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “норматив батлах тухай” А/166, А/559, 222 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-т “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Иргэн Лхагвадоржид тээврийн хөлс ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс 50.0 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3. Багш Ган-Очирт тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэлд 165.4 мянган төгрөг тооцож олгосон нь БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын 8-д “Багш, ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн олбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Тус сургуулийн багш Э.Батжаргал, Б.Ууганбаяр, Б.Баттулга нарт 84.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар баталсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаалын 1-д “Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24000 төгрөг, аймгийн төвд 28000 төгрөг, Уаанбаатар, Эрдэнэт, Дархан-Уу аймагт 32000 төгрөгөөр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д ” бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,011.9 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

2. Нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг 2,294.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ноогдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянган таван зуун) төгрөгөөр тогтоосон”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д

“Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д ” Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллагын дотоод журамд заасны дагуу удаан хугацаагаар өвчтэй байсан 4 багшид 4,633.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон нь цалинтай давхардсан зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

4. Тус сургууль тайлант онд зарцуулсан хүнсний материалын зарлагад хяналт тавиагүйгээс дотуур байрны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах махны норм, хэмжээг хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн нягтлан бодогч Д.Хорлоод сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдлийг сургуулийн багш ажилчдад олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр 8,814.2 мянган төгрөг олгосон байна. Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9-р тушаалын 4.4, 10 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтны ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр дүгнэж, шаардлага хангасан багш, ажилтанд ур чадварын нэмэгдлийг тушаал, шийдвэрийг үндэслэн батлагдсан төсөвтөө багтааж олгох.

